



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/626

Номгон


Соёлын хэлтэс байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5 "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 65 дугаар зүйлийн 65.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны Соёлын хэлтсийг байгуулах тухай 168 дугаар тогтоол, Иргэдийн Төлөөлөгчдын хурлын хуралдааны "Аймгийн 2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 4/15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэрэгжүүлэгч агентлаг "Соёлын хэлтэс"-ийг байгуулсугай.

2.Соёлын хэлтсийн орон тоо, цалингийн сан, техник тоног төхөөрөмж зэрэг, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа), Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Наранбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахын Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д. МӨНХСАЙХАН



601210463